

“УЛААНБААТАР БҮК” ХК-ИЙН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

“УЛААНБААТАР БҮК” ХК нь анх 1984 онд “Байшин Үйлдвэрлэх Комбинат” нэртэй улсын үйлдвэрийн газар хэлбэрээр үүсгэн байгуулагдаж, тухайн үедээ Улаанбаатар хотын орон сууцны барилга байгуулалтын 70 орчим хувийг, Дархан, Эрдэнэт зэрэг төвийн бүсийн хот суурингуудын бүтээн байгуулалтыг бетон зуурмаг болон төмөр бетон хийц эдлэлээр хангаж ирсэн байна.

1998 оноос хувьчлалд орж Монгол Улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй, нээлттэй хувьцаат компани хэлбэрт шилжсэн ба 2006 оноос үйлдвэрлэлийн үйл ажиллагааг зах зээлд нийцүүлэн боловсронгуй болгон хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлснээр өнөөдөр барилгын салбараас гадна зам тээвэр, дэд бүтцийн салбарын бүтээн байгуулалтад өндөр технологи шаардсан нарийн хийц загварын бүтээгдэхүүнээр хангах бүрэн бололцоотой болсон.

Компанийн төмөр замын оролт, өндөр даацын гүүрэн кранууд, орчин үеийн технологийн шийдэл бүхий тоног төхөөрөмжүүд, хагас автомат хэмжилттэй чанарын хяналтын лаборатори, технологийн харилцан уялдааг хангасан зохион байгуулалт зэрэг үйлдвэрлэлийн цогц бааз, мэргэжлийн хүний нөөц нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг чанарын стандартын түвшинд, харьцангуй хямд өртгөөр гүйцэтгэн, хэрэглэгчдэд түргэн шуурхай нийлүүлэх нөхцлийг бүрдүүлсэн. Үүнд:

▪ Үйлдвэрийн нийт талбай	– 140.000 м ²
▪ Үйлдвэрийн барилгын талбай	– 25.000 м ²
▪ Захиргааны барилгын талбай	– 6.000 м ²
▪ Бэлэн бүтээгдэхүүний задгай агуулах	– 42.000 м ²
▪ Битүү агуулах	– 6.000 м ²
▪ Өөрийн төмөр зам	– 1.345 м

2016 ОНД ГОЛ ҮЙЛ ЯВДЛУУД:

1. Компанийн хувьцааг жижигрүүлж, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулав.
2. Эдийн засгийн хямрал, салбарын бууралтаас үүдсэн борлуулалтын бууралт, компанийн санхүүгийн байдлыг харгалзан 2,3 сард сул зогсолт хийж, 4 сараас 88 ажилтанг цомхотголд хамруулав.
3. 18м-ийн дам нуруу болон ф1200 хоолой зэрэг шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэв.
4. Төмөр бетон хийц эдлэлээр нийт 35 захиалагчтай 4,397 сая төгрөгийн гэрээ байгуулав.
5. Компанийн бүтэц зохион байгуулалт, орон тоог шинэчлэн батлав. Батлагдсан бүтэц зохион байгуулалтын дагуу 115 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна..
6. Компанийн үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх, үйл ажиллагааны чиглэлийг нэмэхээр ажиллаж байна.

7. ХАБЭА-г Олон улсын стандартад нийцүүлэх зорилтыг тавин ажиллаж эхлэв.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ:

ТУЗ нь 6 удаа ердийн, 4 удаа эчнээ хуралдаж 23 асуудал шийдвэрлэсэн. Үүнд: \
 Зохион байгуулалтын талаар 9, эдийн засаг санхүү, хөрөнгө оруулалтын талаар 12, журам, дүрэмд өөрчлөлт оруулах засаглалын бодлогын талаар 2 асуудлыг тус тус шийдвэрлэсэн байна.



БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ:

2016 онд метал хийц болон төмөр бетон хийц эдлэлийн үйлдвэрлэл хийж ажилласан. Металхийц үйлдвэрлэлийн хувьд нийт 64,7 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэнээс дотоодын хэрэгцээнд 52,6 тонн, захиалгаар 12,1 тонн хийц үйлдвэрлэн нийлүүлсэн. Үйлдвэрлэлийн хэмжээг 2015 оны гүйцэтгэл болон 2016 оны төлөвлөгөөтэй харьцуулж үзүүлбэл:

Үйлдвэрлэл	2015	2016	2016	2016/2015	2016/2016	Тайлбар
	Гүйцэт		Төлөв	Гүйцэт /%/	Төлөв /%/	
Метал хийц /тн/	402	12.1	0	3.0	100.0	2016 онд нийт 64,7 тонн хийц үйлдвэрлэж, 12,1 тн-г борлуулсан нь 2015 оны 3 хувь болж байгаа бол 2016 онд метал хийц үйлдвэрлэх төлөвлөгөө хийгээгүй
ТБХЭ /м3/	12939	6529	9368	50.5	69.7	2016 онд өнгөрсөн онтой харьцуулахад ТБХЭ-ийн үйлдвэрлэл биет хэмжээгээр 51%, төлөвлөлтийн хувьд 69.7%-г үйлдвэрлэсэн.

САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

№	Үзүүлэлтүүд	2013	2014	2015	2016	↑/↓%
1	Борлуулалт, сая төг	8,887	16,592	8,858	4,707	↓47,6%
2	Нийт ашиг, сая төг	2,402	4,838	2,599	3,639	↓40%
3	Нийт ашгийн түвшин, %	26%	29%	29%	22,7%	↓22%
4	Татвар төлөхийн өмнөх ашиг, сая төг	583	530	-1.5	-2,078	↓39%
5	Цэвэр ашиг, сая төг	512	464	-1.5	-2,078	↓39%
6	Цэвэр ашгийн түвшин	5,80%	2,80%	-16,70%	-44%	↓163%
7	Нэгж хувьцаанд ногдох цэвэр ашиг, төгрөг	454	411	-11.4	-15.8	↓39%
8	1 хүнд ногдох борл.орлого, сая төг	41	71	43	37	↓14%
9	Эргэлтийн харьцаа [1]	0.88	1.07	1.11	1,77	↑59%
10	Эздийн өмчийн өгөөж (ROE), %	5%	1%	-4%	-6%	↓50%
11	Өр ба эздийн өмчийн харьцаа	0.39	0.1	0.11	0,13	↑18%
12	Төлбөр гүйцэтгэх чадвар: (ЭХ-БМ)/БХӨТ	0.24	0.40	0.46	0.75	↑63%
13	ΣХөрөнгийн өгөөж (ROA) ТӨА/Хөрөнгө	0,04	0,01	-0,04	-0,06	↓50%
14	Борл.Ерөнхий Удирдл.Зардал, сая төг	2,090	4,075	4,197	3,288	↓22%
15	Борл.Ер.Удирдл.Зардал/Орлого	0,24	0,26	0,47	0,70	↑49%
16	Сарын цалин, мян.төг	798	1,019	1,012	929	↓8%
17	Ажилтны өгөөж (Цэвэр ашиг/Цалин)	0.25	0.16	-0.6	-1.47	↓145%
18	Үндсэн ҮА-с орсон мөнгө /Борл. Орлого	0.88	1.09	0.96	1,19	↑24%
19	Үндсэн ҮА-нд зарц-сан мөнгө /Борл. Орлого	0.8	0.99	1.07	1,13	↑6%

Борлуулалтын орлого 4.7 тэрбум төгрөг байгаа нь өмнөх онтой харьцуулбал 47.6 хувиар буурсан нь Барилгын салбарын зогсонги байдал, бууралттай шууд холбоотой боловч барилгын салбарын бууралттай харьцуулбал өндөр үзүүлэлттэй байна. Үндэсний статистикийн газрын гаргасан судалгаагаар барилгын салбар тус онд 17.9 хувиар буурсан.

Тус онд нийт ашгийн түвшин буурсан нь борлуулсан бүтээгдэхүүний өртөг өндөр байгаатай холбоотой байна.

2016 онд нэг ажилтанд ногдох дундаж цалин буурсан, ерөнхий ба удирдлагын зардал 0.9 тэрбум төгрөгөөр буурсан боловч 2 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан нь компанийн тогтмол шинжтэй зардлууд өндөр байдагтай шууд холбоотой байна. Үүнд: элэгдэл хорогдлын зардал 1.76 тэрбум төгрөг.

Тогтмол шинжтэй зардлууд өндөр зардлыг хянах, бууруулах боломж бага тул цаашид борлуулатыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллах шаардлагатай.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН:



МУҮН ЛАЙТ ФИНАНС АУДИТ ХХК

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Самбуугийн гудамж 22/2, "Зоос гоёл" ХК-ийн байр 213 тоот
Утас: 99063831, 95951999
И-мэйл: saranchimeg@yahoo.com, nara@cpa.mn

2017/02/24 № А/60/17

Улаанбаатар БҮК ХК-ийн
хувьцаа эзэмшигчдэд

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид 2016 оны 12 дугаар сарын 31 нээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн "Улаанбаатар БҮК" ХК -ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр "Улаанбаатар БҮК" ХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31 ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол Улсын Сангийн Яамнаас батлан гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёсзүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх ба эдгээр шаардлагуудын дагуух ёсзүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

2016.12.31-нээрх санхүүгийн байдлын тайланд тусгагдсан нийт 33,682,633.7 мянган төгрөгийн дансны үнэ бүхий бүх үндсэн хөрөнгийг дараах зээлийн барьцаанд тавьсан. (Тодруулга 4.7)

- Зээл 1. Зээлийн хэмжээ 3.0 тэрбум төгрөг, зээлдэгч Улаанбаатар БҮК ХК.
- Зээл 2. Зээлийн хэмжээ 9.0 тэрбум, үндсэн зээлдэгч Улаанбаатар менежмент ХХК ба тус компани нь Улаанбаатар БҮК ХК-ийн холбоотой тал юм. Энэхүү зээлтэй холбоотойгоор компани сонирхолын зөрчилтэй болон их дүнтэй хэлцлийг том хувьцаа эзэмшигч болох Улаанбаатар менежмент ХХК-тай байгуулсан.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Энэхүү бусад мэдээлэл гэдэгт бидний баталгаажуулсан санхүүгийн тайлан болон өгсөн дүгнэлтэд агуулагдаагүй бусад мэдээлэл хамаарна.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бидний өгсөн дүгнэлт нь уг бусад мэдээллийг хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайланд тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Санхүүгийн тайланд удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд боломжтой болгоход зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа бэлтгэхдээ тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайлан бэлтгэх явдал юм.

Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа бүх буруу тайлагналыг үргэлж илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу тайлагнал нь залилан эсвэл алдаанаас шалтгаалан үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдлийг тодорхойлж үнэлэн, тэдгээр эрсдлүүдэд тохируулахуйц аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлэн, дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоо олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.

- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдал дүгнэлт өгөх зорилгогүй.
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхид материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурьдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсч болох юм.
- Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

Бид засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй аудитын хамрах цар хүрээ, цаг хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Бусад

Энэхүү аудиторын тайланг Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан бэлтгэсэн. Бид уг тайлангийн агуулгын хүрээнд аливаа гуравдагч этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.



МҮҮНЛАЙТ ФИНАНС АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ, МОНГОЛ УЛС

2017 оны 2 дугаар сарын 24

Улаанбаатар БҮК ХК

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Тодруулга	2015.12.31 ний үлдэгдэл	2016.12.31 ний үлдэгдэл
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4.1	13,781.9	133,896.1
Дансны авлага	4.2	1,652,157.7	1,434,060.4
Татвар, НДШ-ийн авлага		-	-
Бусад авлага	4.3	9,243.4	3,972.1
Бусад санхүүгийн хөрөнгө	4.4	10,216.5	45.6
Бараа материал	4.5	2,372,669.8	2,101,278.1
Урьдчилж төлсөн зардал /тооцоо	4.6	25,036.3	25,344.5
Бусад эргэлтийн хөрөнгө		-	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө		-	-
Эргэлтийн хөрөнгийн дүн		4,083,105.6	3,698,596.8
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	4.7	34,851,111.9	33,682,633.7
Биет бус хөрөнгө		-	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт		-	-
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		-	-
Хойшлогдсон татварын хөрөнгө		-	-
ХО-ын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		-	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө		-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		34,851,111.9	33,682,633.7
Нийт хөрөнгийн дүн		38,934,217.5	37,381,230.5
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
Өр төлбөр			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өр төлбөр	4.8	1,974,822.3	845,385.8
Цалингийн өр төлбөр	4.9	110,472.6	93,003.9
Татварын өр төлбөр	4.10.	429,604.7	537,780.0
НДШ-ийн өр төлбөр	4.10.	215,990.7	145,602.0
Богино хугацаат зээл	4.11	764,888.3	325,000.0
Хүүний өглөг	4.11	8,961.6	19,232.9
Ногдол ашгийн өглөг	4.12	67,019.5	67,019.5
Урьдчилж орсон орлого	4.13	109,400.4	58,324.6
Нөөц /өр төлбөр/			
Бусад богино хугацаат өр төлбөр		-	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр		-	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн		3,681,160.1	2,091,348.6

Хавсаргасан тайлбар тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат зээл	4.14	560,300.3	2,675,000.0
Нөөц /өр төлбөр/		-	-
Хойшлогдсон татварын өр		-	-
Бусад урт хугацаат өр төлбөр		-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн		560,300.3	2,675,000.0
Өр төлбөрийн нийт дүн		4,241,460.4	4,766,348.6
Эздийн өмч			
- төрийн			
- хувийн	4.15	131,547.5	131,547.5
- хувьцаат		-	-
Халаасны хувьцаа		-	-
Нэмж төлөгдсөн капитал	4.15	7,225,920.0	7,225,920.0
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4.16	24,994,789.0	24,159,789.5
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		-	-
Эздийн өмчийн бусад хэсэг		-	-
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	4.17	2,340,500.6	1,097,624.9
Эздийн өмчийн дүн		34,692,757.1	32,614,881.9
Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн		38,934,217.5	37,381,230.5

Хавсаргасан тайлбар тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

Улаанбаатар БҮК ХК

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Тодруулга	2015.12.31	2016.12.31
Борлуулалтын орлого (цэвэр)	4.19	8,978,866.8	4,707,081.8
Борлуулалтын өртөг	4.21	6,377,775.7	3,639,279.3
Нийт ашиг		2,601,091.1	1,067,802.5
Түрээсийн орлого	4.20.	184,741.7	127,221.9
Хүүний орлого	4.20.	-	374.1
Ногдол ашгийн орлого		-	-
Эрхийн шимтгэлийн орлого		-	-
Бусад орлого	4.20.	1,079.9	2,655.6
Борлуулалт, маркетингийн зардал	4.22	42,472.3	49,289.3
Ерөнхий ба удирдлагын зардал	4.23	4,151,514.5	3,238,502.7
Санхүүгийн зардал		-	-
Бусад зардал	4.24	3,750.0	6,573.0
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	4.24	(89,230.7)	16,715.1
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-	1,757.9
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		-	-
Бусад ашиг (алдагдал)		-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		(1,500,054.8)	(2,077,837.8)
Орлогын татварын зардал		-	37.4
Татварын дараах ашиг (алдагдал)		(1,500,054.8)	(2,077,875.2)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		(1,500,054.8)	(2,077,875.2)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(1,500,054.8)	(2,077,875.2)
Бусад дэлгэрэнгүй орлого			
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү			
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			
Бусад олз (гарз)			
Орлогын нийт дүн		(1,500,054.8)	(2,077,875.2)
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		(0.0114)	(0.0158)

Хавсаргасан тайлбар тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

Улаанбаатар БУК ХК

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛГИЙН ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эзлийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2014 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	112,827.5	0.0	0.0	26,071,132.1	0.0	0.0	2,764,212.4	28,948,172.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Залруулсан үлдэгдэл	112,827.5	0.0	0.0	26,071,132.1	0.0	0.0	2,764,212.4	28,948,172.0
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	-1,500,054.8	-1,500,054.8
Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Өмчид гарсан өөрчлөлт	18,720.0	0.0	7,225,920.0	0.0	0.0	0.0	0.0	7,244,640.0
Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	0.0	0.0	-1,076,343.0	0.0	0.0	1,076,343.0	0.0
2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	131,547.5	0.0	7,225,920.0	24,994,789.1	0.0	0.0	2,340,500.6	34,692,757.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
Залруулсан үлдэгдэл								
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							(2,077,875.2)	(2,077,875.2)
Бусад дэлгэрэнгүй орлого								
Өмчид гарсан өөрчлөлт								
Зарласан ногдол ашиг								
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				(834,999.5)			834,999.5	
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	131,547.5	-	7,225,920.0	24,159,789.5	-	-	1,097,624.9	32,614,881.9

Хавсаргасан тайлбар тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

Улаанбаатар БҮК ХК

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2015.12.31-ний үлдэгдэл	2016.12.31 ний үлдэгдэл
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<i>Мөнгөн орлогын дүн (+)</i>	8,610,144.3	5,584,152.2
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	8,609,064.4	5,584,036.2
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
Буцаан авсан албан татвар	-	-
Татаас, санхүүжилтийн орлого	-	-
Бусад мөнгөн орлого	1,079.9	116.0
<i>Мөнгөн зарлагын дүн (-)</i>	9,616,696.6	5,338,348.2
Ажиллагчдад төлсөн	1,928,055.4	1,249,931.3
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	301,083.0	355,761.9
Бараа материал худалдан авахад төлсөн	5,083,081.8	1,691,504.9
Ашиглалтын зардалд төлсөн	454,926.0	509,938.4
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	705,679.8	291,730.0
Хүүний төлбөрт төлсөн	107,059.2	195,690.2
Татварын байгууллагад төлсөн	921,341.4	432,929.3
Даатгалын төлбөрт төлсөн	5,275.6	7,058.4
Бусад мөнгөн зарлага	110,194.4	603,803.9
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(1,006,552.3)	245,804.0
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<i>Мөнгөн орлогын дүн (+)</i>	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
Хүлээн авсан хүүний орлого	-	-
Хүлээн авсан ногдол ашиг	-	-
<i>Мөнгөн зарлагын дүн (-)</i>	890,588.4	886,818.8
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	890,588.4	886,818.8
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(890,588.4)	(886,818.8)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<i>Мөнгөн орлогын дүн (+)</i>	1,690,655.2	3,000,000.0
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,690,655.2	3,000,000.0
Хүүний орлого	-	-
<i>Мөнгөн зарлагын дүн (-)</i>	4,800.0	2,238,870.9
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	2,238,870.9
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	4,800.0	-
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
Төлсөн ногдол ашиг	-	-
Валютын ханшийн зөрүү	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	1,685,855.2	761,129.1
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(211,285.5)	120,114.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	225,067.4	13,781.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,781.9	133,896.1

Хавсаргасан тайлбар тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

**Дөрөв. НОГДОЛ АШИГ ТАРААХ ЭСЭХ ТАЛААР
ГАРГАСАН ТУЗ-ИЙН ШИЙДВЭР**

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар Ногдол ашиг тараах эсэх асуудлыг хэлэлцээд “Компанийн тухай” хуулийн 47 дугаар зүйлд заасан ногдол ашиг хуваарилах нөхцөлийн үүсээгүй тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн болно.



**“УЛААНБААТАР БҮК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2017.02.16

№2017/06

Улаанбаатар хот

НОГДОЛ АШГИЙН ТУХАЙ

“Компанийн тухай” хуулийн 46 дугаар зүйлийн 46.5, 47 дугаар заалт, “Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 2-р сарын 16-ны өдрийн ТУЗ-ийн хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Улаанбаатар БҮК”ХК-ийн ногдол ашгийн бодлогын баримт бичгийн 2.2-т заасан ...ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх; гэсэн нөхцөл үүсээгүй тул 2016 оны ажлын үр дүнгээр хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Энэхүү тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх Захирал /Б.Жамбал/, СУГ-ын Захирал /Д.Сувд/- нарт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Н.ХУНЦЭНГЭЛ

**Тав. КОМПАНИЙН 2017 ОНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

ЗОРИЛТУУД:

- Зорилт#1:** Хэрэглэгчдэд оновчтой зөв шийдэл уян хатан сонголт санал болгоно.
Зорилт#2: Борлуулалтын сувгуудыг нэмэгдүүлнэ..
Зорилт#3: Бид захиалагчиддаа ямагт зөв боловсон шуурхай ҮЙЛЧИЛГЭЭ үзүүлнэ.
Зорилт#4: Үйлдвэрлэлийн үр ашгийг сайжруулах шийдлийг тодорхойлж хэрэгжүүлнэ.
Зорилт#5: Чанар стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ..
Зорилт#6: Худалдан авах ажиллагааг сайжруулна.
Зорилт#7: Итгэмжлэгдсэн лабораторийн эрх авна.
Зорилт#8: Техник ТТ-ийн тасралтгүй хэвийн ажиллагааг хангана.
Зорилт#9: Болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, эрүүл ахуйн шаардлага хангана.
Зорилт#10: Үйл ажиллагааны зардлын хяналтыг сайжруулна.
Зорилт#11: Удирдлагын тогтолцоог олон улсын стандартад нийцүүлнэ.
Зорилт#12: Компанийн эрх зүйн байдлыг сайжруулна.
Зорилт#13: Өндөр бүтээмжтэй хамт олныг төлөвшүүлнэ.
Зорилт#14: Хүний нөөцийн чадавхийг сайжруулна
Зорилт#15: Үйл ажиллагаандаа мэдээллийн технологийн инноваци нэвтрүүлнэ.
Зорилт#16: Байгууллагын зөв соёлыг бий болгож, төлөвшүүлнэ.

Макро эдийн засгийн эрэлтийн байдал: Манай бүтээгдэхүүнийг худалдан авагчдын санхүүжилт, үйл ажиллагааг харахад дийлэнх хувийг төсвийн хөрөнгө оруулалт эзэлж байгаа тул 2017 оны улсын төсвийг авч үзэв. сая.төг:

№	Төсвийн хавсралт	2013	2014	2015	2016	2017
1	Монгол улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх ХО-ын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт	1,124,305	1,180,947	655,417	303,632	250,654
2	Хөгжлийн банкны эх үүсвэрээр төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжүүлэх ХО-ын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт			452,351	311,577	172,794
3	МУ-ын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх, концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт				70,705	71,518
	Дүн	1,124,305	1,180,947	1,107,768	685,915	494,968

Хүснэгтээс харахад батлагдсан улсын төсөв жил дараалан буурч ирсэн ба 2017 онд шинээр бүтээн байгуулалт хийгдэхгүй, харин ихэнх ажлууд нь өмнөх жилүүдэд эхэлж хийгдсэн боловч дуусаагүй, царцсан бүтээн байгуулалтуудыг дуусгахад зориулан хөрөнгө оруулалт хийхээр байгаа нь болно. Иймд улсын төсвөөс гарах бүтээн байгуулалтанд оруулах 2017 оны хөрөнгө оруулалтаас манай үйлдвэр шинээр гэрээ авах нөхцөл боломж буурч байна. Барилга дэд бүтцийн салбарын бүтээн байгуулалтын бууралтыг даган материалын эрэлт хэрэгцээ буурах хандлага харагдаж байна.

Борлуулалтын таамаглал: Ойрын жилүүдийн барилга, дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалтын санхүүжилтээр нийт улсын хэмжээнд 6,1 тэрбум ам доллар буюу 15,75 их наяд төгрөгийн дүн бүхий 128 төсөл хөтөлбөр тусгагдсан байна. Үүний 565 тэрбум төгрөг нь 2017 онд хамаарахаар байна. Үүнээс 2017 онд ТБХЭ-ийн үйлдвэрлэлийн салбарын

буюу өөрөөр хэлбэл бид оролцох боломжтой 15 төсөл хөтөлбөрт ногдох дүн 27 тэрбум төгрөг байна. Үүний 18,5%-ийг гүйцэтгэхээр таамаглалаа.

Барилга, дэд бүтцийн салбарын төсөл хөтөлбөрийн санхүүжилт ба 2017 оны ТБХЭ-ийн борлуулалтын таамаглал, тэрбум.төгрөг

№	Санхүүжилтийн эх үүсвэр	Төслийн тоо (үүнээс оролцох боломжтой)	Нийт ХО (оролцох боломжтой)	2017санхүүжилт (оролцох боломжтой)	ТБХЭ салбарт ногдох (оролцох боломжтой)	Борлуулалтын таамаглал
1	Улсын төсөв	39 (0)	306(0)	75(0)	0,5(0)	0,000
2	Хөгжлийн банк	32 (5)	232(29)	49(7)	0,337(0,333)	0,333
3	Гад.зээл тусламж	27 (1)	15082(112)	422(15)	24(3)	3,000
4	Нийслэл төсөв	27 (6)	129(95)	41(22)	1,5(0,8)	0,759
5	Бусад	3 (3)	0,9(0,9)	0,9(0,9)	0,9(0,9)	0,911
	НИЙТ	128 (15)	15750(238)	565(045)	27(5,045)	5,003

Борлуулалтын төлөвлөгөө: 2017 онд борлуулалт өмнөх оноос хамгийн багадаа 40%-аар нэмэгдүүлнэ. Нийт дүнгээр 6,5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүний борлуулалт хийхээр төлөвлөсөн болно. Энэ нь 2017 онд борлуулалтын 8% нь Метал хийц, 77% нь ТБХЭ, 15% нь Товарын Бетон тус тус эзэлнэ.

- Төмөр бетон хийц эдлэл: Барилга дэд бүтцийн бүтээн байгуулалтын 2017 оны санхүүжилтэд дүн шинжилгээ хийснээр, манай үйлдвэрт хамаарах төсөл хөтөлбөрийн 18,5%-тай тэнцэх хэмжээний ажил буюу нийт дүнгээр 5 тэрбум төгрөгийн 6825м3 төмөр бетон хийц эдлэл.
- Метал хийц: хамгийн багадаа 0,5 тэрбум үнийн бүхий 160 тонн бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэхээр төлөвлөж байна. Одоогоор MCS-ийн захиалгат төмөр хогийн сав зэрэг жижиг захиалга гүйцэтгэж байна. Бид 2016 онд ойролцоогоор нийт \$25 сая ам доллар үнийн дүн бүхий Таван толгойн цахилгаан станц болон Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын барилга байгууламжийн метал хийц үйлдвэрлэлийн төслийн тендерт оролцсон, тендерт шалгарах магадлал одоогоор тодорхой бус тул борлуулалын төлөвлөгөөнд тусгагдаагүй болно. Өөрөөр хэлбэл ямар нэгэн тендерт оролцвол, тэр хэмжээгээр борлуулалт нэмэгдэнэ.
- Товарын бетон зуурмаг: Ойролцоогоор 1 тэрбум төгрөгийн 8000м3 бетон нийлүүлэх боломжтой гэж тооцов.

А) Борлуулалт, биет хэмжээсээр

Бүтээгдэхүүн	ХЧ	2013	2014	2015	2016	2017
Метал конструкци, тн	3000	594	1181	261	12	160
Товарын бетон, м3	140000	22022	3560	-	-	8000
Нийт ТБХЭ, м3	59600	9809	12657	12863	6552	6 825
ХНХ, м3	4800	1124	1150	692	496	300
Хоолой/кольцо, м3	18000	-	938	2579	429	252
Бусад ТБХЭ, м3	24000	8685	10569	9469	5627	4 546
Шпал, м3	12800	-	-	123	-	1 727

Б) Борлуулалт, мөнгөн дүнгээр

Бүтээгдэхүүн	ХН	2013	2014	2015	2016	2017
Металконструкци	Саятөг	2514	9813	2981	59	500
ТоварынБетон	Саятөг	2686	543	-	-	1 000
Нийт ТБХЭ	Саятөг	3687	5622	5877	3565	5 003
ХНХ	Саятөг	386	414	219	181	95
Хоолой/кольцо	Саятөг	-	318	1083	164	122
БусадТБХЭ	Саятөг	3301	4890	4435	3220	2 334
Шпал	саятөг	-	-	140	-	2 453
Компанийн дүн	саятөг	8887	15978	8858	3624	6 503

Үйлдвэрийн олон жилийн гүйцэтгэлийн статистик үзүүлэлт ба 2017 оны төлөвлөлт

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017
Орлого (сая төгрөг), Үүнээс:	8887	15978	8858	4707	6607
Металконструкци	2514	9813	2981	59	500
Товарын Бетон	2686	543	-	-	1000
ТБХЭ	3687	5622	5877	3565	5003
Ашгийн маржин, орлогын %	25,9%	28,9%	29,0%	22,7%	27%
БУЕЗ ¹ -ын түвшин, орлогын %	23,6%	26,2%	46,75%	70,0%	60%
Татварын өмнөх ашиг (сая төг)	582,9	530,4	-1500,1	-2077,8	-2053,3

Ашигт ажиллагааны төлөвлөлт: Зах зээлийн судалгаагаар 2017 онд өмнөх онтой харьцуулахад эрэлт 28% орчим хувиар буурахаар байгаа хэдий ч 2017 оны борлуулалтын төлөвлөгөө 2016 онтой харьцуулахад 40%-аар өсөлттэй байна. Түүнчлэн 2017 онд бид үйлдвэрлэлийн үр ашгийг сайжруулах шийдлийг тодорхойлж хэрэгжүүлэх (Зорилт#4) болон үйл ажиллагааны зардлын үр өгөөжийг сайжруулах (Зорилт#10) зорилтуудыг дэвшүүлж байгаа ба үүний үр дүнд ашгийн маржин ба БУЕЗ-ын түвшинг тус бүр хамгийн багадаа өмнөх онтой харьцуулахад 27% ба 60%-аас давуулан сайжруулахаар тус тус төлөвлөж байна.

Төлөвлөсөн орлого үр дүнгийн тайлан:

Үзүүлэлт	2015	2016 төлөвлөгөө	2016 гүйцэтгэл	2017 төлөвлөгөө
Борлуулалтын орлого	8 978 866 824	6 471 365 024	4 707 081 780	6 607 336 994
Нийт ашиг	6 377 775 740	2 264 977 758	1 067 802 458	1 769 529 713
Нийт ашгийн хувь	29%	35,0%	22,7%	27%
Бусад орлого	185 821 593	258 965 290	130 251 552	141 872 727
Борлуулалт, удирдлагын зардал	4 193 986 813	2 555 493 728	3 287 791 926	3 964 722 121
Бусад зардал	3 750 000	0	6 572 956	
БУЗ хувь	46,75%	39,49%	70,00%	60,00%
ТӨА	-1 500 054 805	-31 550 680	-2 077 837 827,79	-2 053 319 681
Ойгооадын өмнөх ашгийн хувь	-16,7%	-0,5%	-44,1%	-31,1%
Цэвэр ашг (алдагдал)	-1 500 054 805	-31 550 680	-2 077 837 828	-2 053 319 681
Цэвэр ашгийн хувь	-16,7%	-0,5%	-44,1%	-31,1%
EPS-Нэгж хувьцаанд ногдох ЦА	-11,40	-0,24	-15,80	- 15,61

¹ БУЕЗ: Борлуулалт Ерөнхий Удирдлагын Зардал



**“УЛААНБААТАР БҮК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2017.02.16

№2017/05

Улаанбаатар хот

Г “Улаанбаатар БҮК” ХК-ийн 2017 оны бизнес төлөвлөгөөг батлах тухай Г

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 18 –р заалт, “Улаанбаатар БҮК” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 28 дахь хэсгийн 2-р заалт, 2017 оны 2-р сарын 16-ны өдрийн ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “УЛААНБААТАР БҮК” ХК-ийн 2017 оны бизнес төлөвлөгөөг “хангалттай” гэж дүгнээд нэгдүгээр хавсралтын дагуу баталсугай.

2. Дээрх төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн улирал бүрийн үйл ажиллагааны гүйцэтгэл үр дүнг дүгнэж ТУЗ-д танилцуулах арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Жамбал/, СУГ-ын Захирал /Д.Сувд/ нарт үүрэг болгосугай.

3. “УЛААНБААТАР БҮК” ХК-ийн 2017 оны бизнес төлөвлөгөөг ХЭХ-д оруулж танилцуулахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Д.Байгальмаа/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Н.ХУНЦЭНГЭЛ

Зургаа. КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА

ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД:

1. ДАВАА ОВОГТОЙ НЯМХҮҮ

1966 оны 1 дүгээр сарын 02-нд төрсөн. 51 настай.

Боловсрол:

1974-1984 Увс аймаг, 1-р дунд сургууль

1984-1989 ОХУ, Хмельницкий хот, Технологийн дээд сургууль,
Технологич инженер ОХУ, Технологийн дээд сургууль, Техникийн
ухааны магистр



Хөдөлмөрийн үйл ажиллагаа:

1998-2000 “Монциркон” ХХК, Ерөнхий захирал

2004-2008 НИТХурал, Төлөөлөгч

2008-2012 Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Дэд сайд

2012-2014 “УБ БҮК” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

2015-2016 оны 7 сар хүртэл- Аж үйлдвэрийн Яамны Төрийн нарийн бичгийн дарга

2016-2017 аанбаатар менежмент”ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн

2. ДОРЖ ОВОГТОЙ МӨНХӨӨ

1967 оны 10 сарын 13-ний өдөр төрсөн, 50 настай

Боловсрол:

Увс аймаг, 1-р дунд сургууль

МУИС-ийн Физикийн факультет, физикч

Хөдөлмөрийн үйл ажиллагаа:

“Шинжлэх ухааны хүрээлэн”, мэргэжилтэн

УАЗТЭШ төв, инженер

“Монциркон” ХК, захирал

“Улаанбаатар БҮК”ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

“Улаанбаатар Менежмент” ХХК, захирал



3. ХАРОН ЮСУПОВИЧ ХАМХОЕВ

1964 оны 05 сарын 20-ний өдөр төрсөн, 53 настай,

Боловсрол:

Ингушетия, дунд сургууль

Казакстан, Карагандинскийн удирдлагын дээд сургууль, эдийн засагч

Хөдөлмөрийн үйл ажиллагаа:

“Лион ЛТД” ХХК, орлогч захирал

“Браз” ХХК-ийн Бээжин дэхь төлөөлөгчийн газар, орлогч захирал

“Браз” ХХК-ийн Казакстан дахь төлөөлөгчийн газар ,орлогч захирал

“Орион Интернейшнл” ХХК, ерөнхий захирал

“Улаанбаатар БҮК”ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



4. СЕРГЕЙ БОРИСОВИЧ ГРОМОВ

1968 оны 04-р сарын 10- ний өдөр төрсөн, 49 настай

Боловсрол:

ОХУ-н Сибирийн Шинжлэх Ухаан Судлалын Их Сургууль
Өнгөт төмөрлөгийн инженер



Хөдөлмөрийн үйл ажиллагаа:

“Чингис Хаан” банк – ТУЗ-н дарга
“Trans World” компани – Сангийн хэлтсийн дарга
“Разноимпорт” компани – Менежер
“Монгол даатгал”ХХК-ийн ТУЗ-ийн дарга
“АПУ”ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
“Улаанбаатар БҮК”ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

5. БАТЖАРГАЛ ОВОГТОЙ ЖАМБАЛ

1980 оны 7 сарын 20-нд төрсөн.37 настай

Боловсрол:

ОХУ-ын Кемерово мужийн Их сургууль-эдийн засагч

Хөдөлмөрийн үйл ажиллагаа:

2004-2016 онд Чингис хаан банк-Байгууллагын банк хариуцсан
дэд захирал

2016 9 сараас “Улаанбаатар БҮК”ХК-ийн Гүйцэтгэх
захирал

2017 Оны 9 сараас “Улаанбаатар БҮК”ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



6. НЯМ ОВОГТОЙ СҮЛДЧИМЭГ

1962 оны 12 сарын 26-нд төрсөн.55 настай.

Боловсрол:

ОХУ,Калининград Цэргийн их сургууль-барилгын инженер

Москва хотын инженерийн академи-удирдлага төлөвлөлт

ШУТИС-Иргэний ба үйлдвэрийн барилгын магистр

БХИС-Зам барилгын магистр

Хөдөлмөрийн үйл ажиллагаа:

1986-1992 онд АА-ийн дугаар ангид инженерийн албаны дарга

1992-1995 онд Батлан хамгаалахын Их сургуульд инженерийн танхимын эрхлэгч

1995-1997 онд “Гал –Со”ХХК-ийн Захирал

1997-1999 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагч Тамгын хэлтсийн дарга

1999-2004 онд Автозамын газарт Захиргаа,санхүүгийн хэлтсийн дарга

2002 онд “Эрдэнэ суварга”ХК-ийн ТУЗ-ийн дарга

2004-2008 онд “Эрдэнэ зам”ХК-д Санхүү эрхэлсэн захирал

2010 онд “Могойн гол”ХХК-ийн захирал

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД:

7. ДОРЖБАЛ ОВОГТОЙ ДЭЛЭГ

1948 оны 06 сарын 29-ний өдөр төрсөн, 69 настай,

Боловсрол:

Улаанбаатар хот, 6-р дунд сургууль

ОХУ, Эрхүү хотын техникийн их суургууль – барилга, замын

машин, төхөөрөмжийн инженер механик

ОХУ, Харьзов хотын ХАДИ – аспирантур

Улаанбаатар хот, Патент судлалын институт – Патент судлаач



Хөдөлмөрийн үйл ажиллагаа:

ШУТИС багш, тэнхимийн эрхлэгч, проректор

“Эрэл” ХХК, ШУхаан үйлвэрлэлийн товчооны дарга

“Материал Импекс” ХК-ийн Гадаад худалдаа үйлдвэрлэлийн дэд захирал

“ШУТИС”, Механик тээврийн сургуулийн багш, механикжуулалт механотроникийн салбарын профессор, Монгол улсын зөвлөх инженер

“Улаанбаатар БҮК” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

8. СҮХБААТАР ОВОГТОЙ БАТБИЛЭГ

..... төрсөн, ... настай.

Боловсрол:

МҮИС-ийн эдийн засгийн сургууль- статистикч, хүн ам зүйч

Их Засаг их сургууль-хуульч

Хөдөлмөрийн үйл ажиллагаа:

1994-1996 онд: Хүн ам, нийгмийн хамгааллын Яамны хүн ам, нийгмийн бодлогын газарт хүн ам зүйн мэдээлэл, статистикийн ажилтан

1998-2002 онд: “Линч ба Махони” хуулийн товчооны төслийн зохицуулагч

2002-2011 онд: Хуулийн болон бизнесийн зөвлөх үйлчилгээний “ЗАТА” ХХК-ийн Гүйцэтгэх захирал

2011-2012 онд: Хуулийн болон бизнесийн зөвлөлгөө өгөх үйлчилгээний “Е.Н.Е” ХХК-ийн Гүйцэтгэх захирал

2012-2014 онд: “Вагнер Ази” ХХК-ийн аж ахуй хариуцсан менежер

2014 оны 5 сараас 2014 оны 10 сар хүртэл: “Их үйлсийн эрэлд групп” ХХК-ийн бизнес хөгжил, хамтын ажиллагааны газрын захирал

2014 оноос одоог хүртэл гадаад худалдаа, Хуулийн болон бизнесийн зөвлөлгөө өгөх үйлчилгээний “Е.Н.Е” ХХК-ийн Гүйцэтгэх захирал

9. ГАЛНЭМЭХ ОВОГТОЙ ЦОГНЭМЭХ

1977 оны 3 сарын 8-ны өдөр төрсөн. 40 настай.

Боловсрол:

Монгол Улсын Техникийн Их сургууль-бизнесийн удирдлагын бакалавр, маркетинг

Монгол Улсын Техникийн Их сургууль-Олон улсын бизнесийн удирдлагын магистр

Испани улсын мадридын Их сургууль- Олон улсын бизнесийн удирдлагын магистр



Хөдөлмөрийн үйл ажиллагаа:

1998-2001 онд: “Проктер энд Кембл”-Төв Ази, Кавказийн худалдааны сүлжээ хариуцсан менежер

2001-2004 онд:”М-Си-Эс Кока-Кола “ХХК- борлуулалт хариуцсан захирал

2004-2006 онд: “Проктер энд Кембл”-Төв Ази, Кавказ улс хариуцсан менежер

2004-2006 онд: “Анунгоо”ХХК, “Проктер энд Кембл” дистрибьюторын Гүйцэтгэх захирал

2006-2007 онд:”Анун”ХХК-ийн гүйцэтгэх захирал

2007-2010 онд: “М-Си-Эс Дистрибьюшин”ХХК-ийн Гүйцэтгэх захирал

2010-2011 онд: “Тэнгэр групп” Бизнес хөгжил хариуцсан дэд Ерөнхийлөгч

2011-2012 онд: “Бишрэлт Холдинг” ХХК-ийн Гүйцэтгэх захирал

2013-2015 онд: “Ремикон”ХК-ийн Гүйцэтгэх Захирал

2015-2016 онд: “Грийн сити” ХХК-ийн борлуулалт хариуцсан захирал

Долоо. КОМПАНИЙН ДҮРЭМД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ

“Улаанбаатар БҮК” ХК нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2015.04.22-ны өдрийн №2015/06 тогтоолоор батлагдсан “Улаанбаатар БҮК” Хувьцаат Компанийн дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулж байна. Компанийн үйл ажиллагаа өргөжиж, хууль тогтоомжид өөрчлөлт орсонтой холбоотойгоор компанийн дүрэмд өөрчлөлт оруулах шаардлага бий болоод байна.

Нэмэлт, өөрчлөлт орох болсон үндэслэл:

- Аудитын тухай хууль 2015.06.19-ний өдөр шинэчлэн батлагдсан.
- Компанийн тухай хуульд 2014.06.05-ны өдөр, 2015.06.19-ний өдөр тус тус өөрчлөлт орсон.
- Санхүүгийн зохицуулах хорооны Улаанбаатар БҮК” ХК-д 2017.01.20-ны өдрийн 9/210 тоот компанийн дүрмэнд өөрчлөлт оруулахыг даалгасан албан бичиг ирсэн.
- Компанийн үйл ажиллагааны чиглэлийг компанийн дүрэмд нэмж оруулах шаардлагатай болсон.

Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтүүд:

1. Компанийн дүрмийн 3.3.1 дэх хэсэгт:

Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл гэсэн заалтанд нэмэлтээр оруулах;

1. Барилгын материал үйлдвэрлэлийн чиглэлээр
 - Төмөр бетон эдлэл үйлдвэрлэх;
 - Даацын металл хийц эдлэлийн үйлдвэрлэл;
 - Бетон зуурмагийн үйлдвэрлэл;
 - Элс хайрга бутлан ангилах үйлдвэрлэл;
2. Өргөх байгууламжийн чиглэлээр
 - Ачаа өргөх кран, төрөл бүрийн өргүүрийн /барилгын өргүүр, манипуляторын кран; сагстай өргөгч/ угсралтын ажил, засвар, техникийн үйлчилгээ;
 - Өргөх байгууламж, түүний эд анги үйлдвэрлэл;
3. Төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх
4. Барилга угсралтын чиглэлээр
 - Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн барилгын ажил /1-16 давхар хүртэл/
 - Цамхаг, тулгуур, түшиц хана, яндан антенна зэрэг 30 м хүртэл өндөр угсармал ба цутгамал бетон, төмөр бетон, ган бүтээцтэй байгууламжийн ажил
5. Авто замын чиглэлээр
 - Авто замын барилга байгууламж барих, засварлах /гүүр, туннел/
6. Төмөр замын чиглэлээр
 - Төмөр замын дээд бүтэц үйлдвэрлэх /Төмөр бетон дэр үйлдвэрлэх/;
 - Төмөр замын бүх төрлийн гүүр, гүүрэн гарам барих
7. Зураг төслийн чиглэлээр
 - Барилга, зам гүүрийн зураг төсөл боловсруулах гэж нэмэлт оруулах.

2. Компанийн дүрмийн 7.5 дахь заалтад: “Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэгт заасан тохиолдолд” гэж нэмэлт оруулах;

Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх заалтад Хувьцаа эзэмшигчдийн хуралыг зарлан хуралдуулах тохиолдлуудыг заасан байна. Эдгээр заалтуудын зарим нь компанийн дүрэмд байхгүй байна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй дүрмийн 7.5 дахь заалт:

“Шаардлагатай үед ТУЗ эсхүл ТУЗ-ийн 2-оос доошгүй хараат бус гишүүн, саналын эрхийн 10-аас доошгүй хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдийн санаачилгаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг ТУЗ-өөс зарлан хуралдуулах, ТУЗ энэхүү үүргээ хэрэгжүүлээгүй бол тухайн этгээд өөрөө зарлан хуралдуулах эрхтэй”.

3. Компанийн дүрмийн 7.6 дах заалтын 11 дэх хэсэгт:

“ТУЗ-өөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхолын зөрчилтэй хэлцлийг батлах” гэж өөрчлөлт оруулах;

Компанийн тухай хуулийн 62.1.11 дэх хэсэгт “ТУЗ-өөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй бол” гэсэн нөхцөл нэмэгдсэн байна. /Энэ заалтад 2014 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан.

Одоо үйлчилж буй дүрмийн 7.6 дахь заалтын 11 дэх хэсэгт: “Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхолын зөрчилтэй хэлцлийг батлах” гэж заасан.

Компанийн дүрмийн энэ заалтад Зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ гэж заасан байна.

4. Компанийн дүрмийн 7.6 дах заалтын 12 дахь хэсэгт

“Компанийн тухай хуульд заасаны дагуу компани өөрийн гаргасан хувьцааг худалдан авахыг зөвшөөрөх” гэж өөрчлөлт оруулах;

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа компанийн дүрмийн 7.6.12 дахь хэсэгт: “Компанийн тухай хуульд заасаны дагуу компани өөрийн гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг худалдан авахыг зөвшөөрөх” гэж заасан байна.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Компанийн тухай хуулийн 62.1.12 дахь заалтад ямар нэг хувь хэмжээ заагаагүй байна.

5. Компанийн дүрмийн 7.28 дах заалтын 9 дэх хэсэгт:

“Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй, тусгай зөвшөөрөлтэй Аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцлийг тогтоох” гэж өөрчлөлт оруулах;

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1.6 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооноос “Улаанбаатар БҮК” ХК-д илгээсэн 2017.01.20-ны өдрийн 9/210 тоот албан бичгийг үндэслэсэн болно.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй дүрмийн 7.28 дах заалтын 9 дэх хэсэг: “Компанийн аудиторыг сонгож, түүнтэй хийх гэрээний нөхцлийг тогтоох” гэж заасан.

6. Компанийн дүрмийн 7.35 дахь заалтад:

7.35. “ТУЗ-ийн гишүүн удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлж чадахгүй болсон, нас барсан тохиолдолд орлох гишүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах хүртэл ТУЗ томилно” гэж өөрчлөлт оруулах.

Компанийн тухай хуулийн 77.5 дахь заалтын дагуу ТУЗ-ын гишүүнийг ТУЗ түр томилохоор заасан байна. Гэтэл одоо үйлчилж буй дүрэмд ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хороо ТУЗ-ийн гишүүнийг түр томилохоор заасан байна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй дүрмийн 7.35 дах заалт: “ТУЗ-ийн гишүүн удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлж чадахгүй болсон, нас барсан тохиолдолд орлох гишүүнийг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах хүртэл ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хороо түр томилно”.

7. Компанийн дүрмийн 7.40.3 дахь хэсэгт:

7.40.3. Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин урамшууллыг тогтоох санал боловсруулах” гэж өөрчлөх. Компанийн тухай хуулийн 81.4.2 дахь заалтын дагуу.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй дүрмийн 7.40.3 дахь заалт: “Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин урамшууллын талаарх гүйцэтгэх удирдлагын саналыг хянах, ТУЗ-д танилцуулах”.

8. Компанийн дүрмийн 7.54 дэх заалтад:

“ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Санхүү удирдлагын газрын захирал, ерөнхий нягтлан бодогч, компанийн албан ёсны шийдвэр гаргахад болон гэрээ хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно” гэж өөрчлөлт оруулах;

Компанийн тухай хуулийн 84.1 дэх заалтын дагуу зарим этгээдүүд эрх албан тушаалтнууд нэмэгдсэн болно.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй 7.54 дэх заалт: “ТУЗ-ын дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцогдоно”.

9. Компанийн дүрмийн 8.4 дэх заалтад:

“Компани дор дурдсан бүртгэлийг заавал хөтлөх бөгөөд бүртгэлийг үнэн зөв, бүрэн хөтлөх, холбогдох бичиг баримтыг зохих журмаар хадгалах, архивт шилжүүлэх нь компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга хариуцах асуудал болно” гэж өөрчлөлт оруулах;

Компанийн тухай хуулийн 97.1 дэх заалтын дагуу дээрх асуудлыг ТУЗ-ын Нарийн бичгийн дарга хариуцахаар заасан байна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй 8.4 дэх заалт: “Компани дор дурдсан бүртгэлийг заавал хөтлөх бөгөөд бүртгэлийг үнэн зөв, бүрэн хөтлөх, холбогдох бичиг баримтыг зохих журмаар хадгалсан байх нь гүйцэтгэх захирлын хариуцах асуудал болно”.

10. Компанийн дүрмийн 9.8 дахь заалтад:

“Аудитын тухай хууль, Компанийн тухай хуульд заасаны дагуу компани нь санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор хөндлөнгийн аудитын байгууллагыг заавал ажиллуулна” гэж өөрчлөлт оруулах;

Компанийн тухай хуулийн 94.2/*Энэ хэсэгт 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан*/, 2015 оны 6 сарын 19-ний өдөр шинэчлэн батлагдсан Аудитын тухай хуулийн 10.1.1 дэх заалтыг, мөн Санхүүгийн зохицуулах хорооноос Хувьцаат компани аудитын байгууллагыг заавал ажиллуулна гэсэн заалтыг компанийн дүрмэндээ оруулахыг даалгасаныг үндэслэн.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй дүрмийн 9.8 дахь заалт: “Аудитын тухай Монгол улсын хуульд заасаны дагуу компани нь санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгон гэрээ байгуулж, ажиллуулна”.

**Найм. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААС
ГАРАХ ТОГТООЛЫН ТӨСЛҮҮД**

**“УЛААНБААТАР БҮК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2017 оны 04-р сарын 26-ны өдөр

№2017/01

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн
хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1 дэх заалт, 67 дугаар зүйлийн 67.3.8 дах заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, Компанийн дүрмийн 7.10 дахь заалт, Тооллогын комиссын санал хураалтын дүнгийн талаарх тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигчид биеэр оролцож байгаа нь нийт саналын эрх бүхий энгийн хувьцаа болох энгийн ширхэг хувьцааны% болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.

2. Компанийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийн заалт, Компанийн дүрмийн 7.4 дэх заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны% - ийг эзэмшигчид хуралд оролцож байгаа учраас компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

Д.БАЙГАЛЬМАА

“УЛААНБААТАР БҮК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 04-р сарын 26-ны өдөр

№2017/...

Улаанбаатар хот

Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх хэсэг, Компанийн дүрмийн
7.6.9 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Улаанбаатар БҮК” ХК-ийн 2017 оны Компанийн жилийн үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Н.ХУНЦЭНГЭЛ

“УЛААНБААТАР БҮК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 04-р сарын 26-ны өдөр

№2017/...

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг чөлөөлөх, сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь заалт, Компанийн дүрмийн 7.6.7 дахь заалт, “Улаанбаатар БҮК”ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журам”-ын 9.4 дэх заалт, Тооллогын комиссын 2017 оны 04 сарын....ны өдрийн№.....шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг тус өдрөөр тасалбар болгон чөлөөлж, доорх нэр бүхий хүмүүсийг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнээр сонгосугай.

Ердийн гишүүд:

- Д.Нямхуу
- Д.Мөнхөө
- С.Б.Громов
- Х.Ю.Хамхоев
- Б.Жамбал
- Н.Сулдчимэг

Хараат бус гишүүд

- Д.Дэлэг
- С.Батбилэг
- Г.Цогнэмэх

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин урамшууллыг батлагдсан төсвийн хүрээнд ТУЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн батлахыг зөвшөөрсүгэй.
3. Компанийн тухай хууль болон холбогдох журмын дагуу ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн дэргэдэх хороодын томилох ажиллахыг ТУЗ-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Н.ХУНЦЭНГЭЛ

**“УЛААНБААТАР БҮК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2017 оны 04-р сарын 26-ны өдөр

№2017/...

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16, Компанийн дүрмийн 7.6.13 дахь заалт, Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Улаанбаатар БҮК” ХК-ийн 2017 оны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн төсвийг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Н.ХУНЦЭНГЭЛ

*“Улаанбаатар БҮК” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
2017 оны 04-р сарын 26-ны өдрийн хурлын тоот
тогтоолын хавсралт*

ТУЗ-ИЙН 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ

№	Үйл ажиллагаа	нэг сард ноогдох зардал /мян.төг/	жилийн зардал /мян. төг/	тайлбар
1	2017 оны үйл ажиллагааны зардал		4 711,0	
2	ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал		64 368,0	
	дүн		69 079,0	

“УЛААНБААТАР БҮК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 04-р сарын 26-ны өдөр

№2017/...

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 62 дугаар зүйлийн 62.1.16, Компанийн дүрмийн 7.6.13 дахь заалт, Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Улаанбаатар БҮК” ХК-ийн дүрэмд хавсралтад заасан нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай.
2. Компанийн дүрмийн өөрчлөлтийг Оюуны өмч, улсын бүртгэлийн газарт бүртгүүлэн, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Гүйцэтгэх захирал Б.Жамбалд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Н.ХУНЦЭНГЭЛ

Арав. ХУРЛЫН САНАЛ ХУРААХ ХУУДАС.

**“УЛААНБААТАР БҮК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН
САНАЛЫН ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2017 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 11.00 цагт Баянгол дүүргийн 20-р хороо, Дунд голын эрэгт байрлах компанийн өөрийн байранд хуралдана.

Хувьцаа эзэмшигч /эсхүл төлөөлөх этгээд/-ийн эцгийн нэр, өөрийн нэр: _____

Итгэмжлэлийн дагуу төлөөлж байгаа бол хэнийг, эсхүл ямар хуулийн этгээдийг төлөөлж буй хэн болох тухай тайлбар: _____

Регистрийн дугаар: _____

Гэрийн хаяг, утасны дугаар, цахим хаяг: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл, тоо ширхэг: энгийн, _____

Саналын эрхтэй хувьцааны тоо: _____

Саналын өгөх арга: энгийн

Хэлэлцэн шийдвэрлэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.2016 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах			
2.Ногдол ашгийн талаарх ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;			
3.”Улаанбаатар БҮК”ХК-ийн 2017 оны бизнес төлөвлөгөөг танилцуулах			
4. ТУЗ-ийн 2017 оны төсөв батлах			
5. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг батлах			

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг: _____ / _____ /

2017 оны сарын-ний өдөр

Саналын хуудсыг хүчинтэй/хүчингүйд тооцон тоолсон:

Хүчингүйд тооцсон бол шалтгаан нь:

Комиссын дарга: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга-Д.Байгальмаа

Гишүүд: Хуульч Д.Нармандах
..... Хүний нөөцийн менежер Б.Оюунтуяа
..... Нягтлан бодогч Р.Энх-Амгалан

**“УЛААНБААТАР БҮК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
САНАЛЫН ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2017 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 11.00 цагт Баянгол дүүргийн 20-р хороо, Дунд голын эрэгт байрлах компанийн өөрийн байранд хуралдана.

Хувьцаа эзэмшигч /эсхүл төлөөлөх этгээд/-ийн эцгийн нэр, өөрийн нэр: _____

Итгэмжлэлийн дагуу төлөөлж байгаа бол хэнийг, эсхүл ямар хуулийн этгээдийг төлөөлж буй хэн болох тухай тайлбар: _____

Регистрийн дугаар: _____

Гэрийн хаяг, утасны дугаар, цахим хаяг: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл, тоо ширхэг: энгийн, _____

Саналын эрхтэй хувьцааны тоо: _____

Саналын өгөх арга: кумулятив

Хэлэлцэн шийдвэрлэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1. ТУЗ-ийн гишүүдийг сонгох ЕРДИЙН гишүүнээр:			
1.			
2.			
3.			
4.			
5.			
6.			
ХАРААТ БУС гишүүнээр			
1.			
2.			
3.			

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг: _____ / _____ /

2017 оны сарын-ний өдөр

Саналын хуудсыг хүчинтэй/хүчингүйд тооцон тоолсон:

Хүчингүйд тооцсон бол шалтгаан нь:

Комиссын дарга: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга-Д.Байгальмаа

Гишүүд: Хуульч Д.Нармандах
 Хүний нөөцийн менежер Б.Оюунтуяа
 Нягтлан бодогч Р.Энх-Амгалан

ТУЗ-ийн гишүүдийг санал хураах кумулятив аргаар сонгоно. Энэ аргаар саналын тоог тогтоохдоо таны эзэмшиж буй хувьцааны тоог 9-өөр үржүүлнэ. Та ингэж тооцсон саналынхаа 2/3-ыг энгийн гишүүнд, 1/3-ыг хараат бус гишүүнд нэр дэвшигчдэд өгнө. Жишээ нь: та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 6 нь ердийн, 3 нь хараат бус гишүүн байхаар дүрэмд заасан учраас та 900 саналынхаа /100*9гишүүн=900/ 600-г ердийн гишүүнд нэр дэвшигчдэд, 300-г хараат бус гишүүнд нэр дэвшигчдэд дурын хувилбараар хувааж, тухайн нэр дэвшигчид өгч буй саналынхаа тоог тэмдэглэнэ. Таны өгсөн нийт саналын тоо 900-аас илүү юмуу дутуу байж болохгүй.

